



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 829

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Япон улс дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв”-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын явцад сэргээн засварлах боломжгүй болсон, 6 нэрийн, нийт 5,972,919.84 (таван сая есөн зуун далан хоёр мянга есөн зуун арван есөн төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 2,923,309.56 (хоёр сая есөн зуун хорин гурван мянга гурван зуун есөн төгрөг тавин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, Япон улс дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв”-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Хорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007446

37-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
8.2.9... дугаар тогтоолын хавсралт

Япон улс дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв”-ийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлаж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Нийт хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ширээ тусгаарлагч	2020.12.31	1	362,355.84	362,355.84	302,610.00	59,745.84
2	Туузан хөшиг	2020.12.31	1	3,026,100.00	3,026,100.00	36,235.56	2,989,864.44
3	Вирусны програм	2013.03.16	1	199,429.80	199,429.80	199,429.80	0.00
4	Динамик санхүүгийн программ	2021-04-23	1	1,214,860.00	1,214,860.00	1,214,860.00	0.00
5	Хэрэглээний программ	2021-03-31	1	985,327.20	985,327.20	985,327.20	0.00
6	Вирусны программ	2022-05-19	1	184,847.00	184,847.00	184,847.00	0.00
	Нийт дүн		6		5,972,919.84 (таван сая есөн зуун далан хоёр мянга есөн зуун арван есөн төгрөг наян дөрвөн мөнгө)	2,923,309.56 (хоёр сая есөн зуун хорин гурван мянга гурван зуун есөн төгрөг тавин зургаан мөнгө)	3,049,610.28 (гурван сая дөчин есөн мянга зургаан зуун арван төгрөг хорин найман мөнгө)